



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 5/83

Хэрлэн сум

Н.Нямсүрэнг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.1.8, Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Засгийн газрын 2007 оны 354, 2014 оны 208 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/3242 дугаар албан бичгийн дагуу аймгийн Музейн захирлын сул орон тоонд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны шаардлага хангасан Нанзадын Нямсүрэнг 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Аймгийн Музейн захирлын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Нямсүрэнд үүрэг болгосугай.

3. Н.Нямсүрэнгийн үндсэн цалинг ТҮСУ-8-5 шатлалаар 711230 /долоон зуун арван нэгэн мянга хоёр зуун гучин/ төгрөгөөр тогтоож олгохыг Музейн нягтлан бодогч /Б.Мөнхзул/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА